



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2023/06/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2021 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор Ж.Бүжинханд Утас: 99177546 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ДЭЛГЭР
СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.ЧИНЗОРИГ
ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2022.03.24 № 132

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төв, Соёлын төв, сургууль, цэцэрлэгийн хөрөнгө, өр төлбөрийн эхний үлдэгдэл шилжсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 9 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 88.3 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0702000317

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,012,673.2	604,165.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,163,067.7	1,166,976.2
	Нийт хөрөнгийн дүн	4,175,741.0	1,771,141.2
	Нийт өр төлбөрийн дүн	87,119.7	1,537.6
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,088,621.3	1,769,603.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,175,741.0	1,771,141.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	4,523,351.6	1,174,528.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	3,780,559.4	903,878.3
	Үйл ажиллагааны үр дүн	742,792.2	270,650.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	198,655.7	2,414,297.6
	Үйл ажиллагааны нийт үр дүн	544,136.5	-2,143,647.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,546,564.4	4,088,621.3
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,079.6	-175,370.3
	Тайлант оны үр дүн	544,136.5	-2,143,647.5
	Эцсийн үлдэгдэл	4,088,621.3	1,769,603.5
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,611,784.8	1,226,962.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,302,448.8	808,842.7
	Үйл ажиллагааны ЦМГ	309,336.0	418,119.6
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-220,331.7	-346,032.4
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-53,000.0	-14,000.0
	Бусад эх үүсвэр	0.0	0.0
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	36,004.2	58,087.1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	137,549.0	173,553.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	173,553.2	231,640.3

Гурав. Аудитын илрүүлэлт:**3. Аудитын илрүүлэлт**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 1 төрийн сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн.

Нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

Төвлөрүүлэн захирагчийн харьяа нэгж, байгууллагуудад 698.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 448.9 сая төгрөгийн алдааг залруулж, 49.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 584.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж 3 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар алдаа илрээгүй. Аудитаар 26.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Албан шаардлага

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үзэхэд хөрөнгийн орлого 0.8 сая төгрөгөөр, бууны албан татварын орлого 0.1 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 0.4 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 0.05 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 0.2 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" Дэлгэр сумын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 31 дүгээр тогтоолыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дэлгэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	0	-	0	-	0	-	0	-				
Дэлгэр сумын ЗДТГ	1	87.10	0	-	1	87.10	1	87.10				
Дэлгэр сумын ИТХ	1	0.30	0	-	1	0.30	1	0.30				
Дэлгэр сумын ОНХС	2	307.80	0	-	2	307.80	2	307.80				
Дэлгэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	53.76	0	-	1	53.76	1	53.76				
Дэлгэр сумын БХНС сан	0	-	0	-	0	-	0	-				
Дүн	5	448.96	0	-	5	448.96	5	448.96				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Дэлгэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	0	-	0	0	0	0	0	0	0	0		
Дэлгэр сумын ЗДТГ	17	118.82	7	16.61	9	101.01	1	1.20	0	-		
Дэлгэр сумын ИТХ	9	8.70	5	3.30	3	5.40	0	-	1	1.00		
Дэлгэр сумын ОНХС	2	4.34	1	4.34	0	-	0	-	1	1.00		
Дэлгэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	5	71.83	1	25.27	3	46.56	1	-	0	-		
Дэлгэр сумын БХНС сан	0	-	0	-	0	-	0	-	0	-		
Дүн	33	203.69	14	49.52	15	152.97	2	1.20	2	2.00		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дэлгэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	-	0	-	1	-	0	1
Дэлгэр сумын ЗДТГ	0	-	0	-	0	-	0	-
Дэлгэр сумын ИТХ	0	-	0	-	0	-	0	-
Дэлгэр сумын ОНХС	0	-	0	-	0	-	0	-
Дэлгэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	0	-	0	-	0	-	0	-
Дэлгэр сумын БХНС сан	0	-	0	-	0	-	0	-
Дүн	1	-	0	-	1	-	0	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дэлгэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	26.80	0	-	1	26.80	0	-
Дэлгэр сумын ЗДТГ	3	19.14	0	-	2	19.14	1	-
Дэлгэр сумын ИТХ	0	-	0	-	0	-	0	-
Дэлгэр сумын ОНХС	0	-	0	-	3	385.57	0	-
Дэлгэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	0	-	0	-	0	-	0	-
Дэлгэр сумын БХНС сан	0	-	0	-	0	-	0	-
Дүн	4	45.94	0	-	6	431.51	1	-
Нийт дүн	5	45.94	0	-	7	431.51	1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1	-	-	1		-	-
2	ТШЗ	2	1	1			1		
3	ОНТС	3		3					
	НИЙТ	7	3	4	-	1	2	-	-